

**ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА М.ТУУЛЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: Төрийн албаны Говь-Алтай аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		68.0

1. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.			14.0
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			+

2. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	15
2.	Удирдан зохион байгуулах	14
3.	Асуудал шийдвэрлэх	15
4.	Манлайлах	15
5.	Багаар ажиллах	14
6.	Харилцаа	15
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		14.5

3. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	68.0
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	14.0
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	14.5
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	—
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо +		96.5

Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар
хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо

Үнэлгээ өгсөн:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

Төсвийн шууд захирагч

(гарын үсэг)

/Ш.ЭРДЭНЭБАТ/

(албан хаагчийн нэр)

2025.12.04 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
(албан тушаал)

Нэгжийн дарга:

(гарын үсэг)

/М.ТУУЛ/

(албан хаагчийн нэр)

2025.12.03 (огноо)

Үнэлгээний багийн ахлагч:
Хяналт-шинжилгээ үнэлгээний
Хэлтсийн дарга
(албан тушаал)

(гарын үсэг)

/Д.БУЯНХИШИГ/
(албан хаагчийн нэр)

2025.12.11 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичиг:
Хүний нөөцийн бодлого хариуцсан
мэргэжилтэн
(албан тушаал)

(гарын үсэг)

/Ч.НЯНДАГ/
(албан хаагчийн нэр)

2025.12.11 (огноо)

ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА М.ТУУЛЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь
НЭГ: САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАСРАЛТГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ							
Зорилт 1.1. Дотоод зохион байгуулалт, чадавхыг бэхжүүлэх							
1.	Төрийн албаны тухай хууль болон төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагуудын болон Сумдын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлэх.		Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байгууллагын тоо	0	10	Төрийн албаны зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу Говь-Алтай аймагт ажиллах ажлын хэсэгтэй хамтран Тонхил, Дарив, Бугат, Төгрөг, Шарга сумдуудад ажиллаж, төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хийж, төрийн албан хаагчдаас судалгаа авч, сургалт өгч, арга зүйгээр хангаж, салбар зөвлөлөөс хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар мэдээлэл хийж, сул орон тоо, зөрчилтэй томилгоонд дүн шинжилгээ хийж ажиллалаа. Мөн Дарив, Цээл, Хөхморьт, Шарга сумын төрийн албан хаагчийн нэгдсэн сургалт, зөвлөгөөнд оролцож, 450 төрийн албан хаагчдад “Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт”, Төрийн албаны шинэтгэл, сонгон шалгаруулалт”, “Төрийн албанд тавигдах шаардлага, стандарт” сэдвээр сургалт хийлээ. Төрийн байгууллагуудын 60 хүний нөөцийн ажилтнуудад “Төрийн албаны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт”-ээр сургалт хийлээ. Сумдын засаг дарга, Сумдын тамгын газрын дарга нарт Төрийн албаны тухай хууль болон төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр 2 удаа сургалт мэдээллийг аймгийн төвд хийлээ.	100

2.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, Төрийн байгууллагуудын дэргэдэх ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах		Зохион байгуулах сургалтын тоо	1	3	Төрийн албаны албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор Төрийн албаны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиудаар 7 байгууллагад арга зүйн зөвлөгөө өглөө. 2025 оны хагас жилийн байдлаар ёс зүйн мэдээ тайлан гаргахад аймгийн хэмжээнд 14 ёс зүйн зөрчил гарсан байна.	100
3.	Төрийн аудитын газраас хүний нөөцийн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр Төрийн байгууллагуудад зөвлөмж боловсруулж хүргүүлэх.		Зөвлөмжийн тоо	1	2	Төрийн аудитын газраас хүний нөөцийн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр Төрийн байгууллагуудад салбар зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар албан бичгээр 6 чиглэлийн зөвлөмжийг хүргүүлэн, хэрэгжилтийг хангах чиглэл өгсөн. 2025 онд зөрчил дутагдлыг арилгах зорилгоор Төрийн албаны тусгай шалгалтыг 2025 онд 5 удаа зохион байгуулж, нийт 203 сул орон тооны тусгай шалгалтыг зарлаж, тэнцсэн 72 иргэнийг томилох эрх бүхий албан тушаалтад нэр дэвшүүлсэн тогтоолыг хүргүүлж, сул орон тоог нөхлөө.	100
4.	Салбар зөвлөлийн эрх хэмжээний хүрээнд тогтоол, шийдвэр гаргаж хэрэгжилтийг хангуулан ажиллах.		Шийдвэрийн хэрэгжилтийн хувь	100	100	Төрийн албаны салбар зөвлөл үйл ажиллагаагаа хамтын удирдлагын зарчмаар явуулж Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журмын 4.2 дахь заалтад "Салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна" гэж заасны дагуу 2025 онд салбар зөвлөлийн хуралдааныг 10 удаа зохион байгуулж, 63 тогтоол гаргаж, хэрэгжүүлэн ажилласан.	100

5.	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлэх.	Хугацаан д нь хүргүүлсэ н тоо	2	2	Төрийн албаны зөвлөлийн ажлын алба болон газруудаас ирсэн хугацаатай, тайлан мэдээг, тухай бүр хугацаанд нь шуурхай гаргаж хүргүүлсэн. Хагас, бүтэн жилийн Салбар зөвлөлийн зурган тайлан, 13 төрлийн судалгааг аймгийн хэмжээнд нэгтгэн гаргаж, хугацаанд нь төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн	100
6	Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл олгосон төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг баталж, мөрдүүлэх ажлыг удирдлагаар хангах	Байгуулл агуудын тоо	3	20	Төрийн албаны зөвлөлөөс 2025 онд шинээр зөвшөөрөл олгосон аймгийн ОНХС мэргэжилтэн. ХХААГ-ын дарга, сумдын ХААТ-н мэргэжилтэн, Боловсролын газрын удирдах, гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтуудыг томилох эрх бүхий албан тушаалтнаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Мөн сумдын Засаг даргын тамгын газрын 6 албан тушаалын тодорхойлолт жишгээр ирснийг томилох эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан, Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. АТТ-ыг ХНУМТ цахим системд оруулах ажлыг эрчимжүүлэн 100 гаруй байгууллагын 540 гаруй АТТ-ыг хянаж, баталгаажуулаад байна. Мөн аймгийн ЗДТГ-ын албан тушаалын тодорхойлолтод зөвшөөрөл авахаар төрийн албаны зөвлөлд 2025.07 сард хүргүүлсэн.	90
ХОЁР: ТӨРИЙН АЛБАНЫ ЕРӨНХИЙ БОЛОН ТУСГАЙ ШАЛГАЛТЫГ НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ТАЛААР						
Зорилт 2.1 Төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулах, тэнцсэн иргэдийг нөөцийн жагсаалтад бүртгэх, хэрэгцээг хангах ажлыг зохион байгуулах						
7.	Төрийн байгууллагуудаас ирүүлсэн сул орон тооны захиалгыг нэгтгэн, шилжих сэлгүүлэх ажлын байрны жагсаалтыг олон нийтэд нээлттэй мэдээлэх	Мэдээлсэ н тоо	4	4	2025 оны хагас жилийн байдлаар төрийн байгууллагуудаас сул орон тооны захиалгыг авч нийт 101 ажлын байрны шилжүүлэх, сэлгүүлэх зарыг олон нийтэд мэдээлэн ажиллаж, 13 сул ажлын байрыг нөхлөө.	100

8.	Сул орон тооны захиалгыг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн, шалгалт зохион байгуулах салбар комиссыг томилно	Комисс томилох тоо	8	8	2025 оны хагас жилийн байдлаар тусгай шалгалтыг 3 удаа зарлаж, нийт 149 сул ажлын байрны захиалгыг авч, хянан, салбар зөвлөлийн хуралд танилцуулан, ТА3-д захиалгыг хүргүүлэн шалгалтыг 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж 30 оролцогч шалгалтад тэнцэж, 24 иргэнийг салбар зөвлөлийн тогтоолоор нэр дэвшүүлэв. Мөн дараагийн тусгай шалгалтыг 2025 оны 04 сарын 23-нд зохион байгуулахаар зарласан боловч шаардлага хангасан оролцогч байхгүй тул бүгдийг цуцалсан. 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр 37 сул ажлын байрны сонгон шалгаруулалтыг зарласан.	100
9.	Ерөнхий болон тусгай шалгалтыг чанартай зохион байгуулж, шалгалтын дүн мэдээг Төрийн албаны зөвлөлд хугацаанд нь хүргүүлж, архивын нэгж болгоно.	Шалгалт зохион байгуулах тоо	8	8	Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.7, 33.10 дахь хэсэгт заасны дагуу "Төрийн албаны ерөнхий шалгалт"-ын бүртгэлийг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар бүртгэж, 4 удаа зохион байгууллаа. 2025 оны ерөнхий шалгалтын бүртгэлд нийт 328 иргэн хамрагдаж, шалгалтад 262 иргэн орж, 2025 оны I-IV улирлын ерөнхий шалгалтад нийт 87 иргэн тэнцэж, нөөцөд бүртгэгдлээ. 2025 онд тусгай шалгалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд 5 удаа нийт 203 сул ажлын байрны захиалгыг хүргүүлэн, сонгон шалгаруулалтыг хуулийн хугацаанд нь зохион байгуулж, 72 сул ажлын байрыг нөхөөд байна.	100

10.	Албан тушаалын сул орон тоонд зохих журмын дагуу нэр дэвшүүлэх, нэр дэвшүүлсэн шийдвэрийн хэрэгжилтэд, хяналт тавих, ил тод мэдээллээр зохих хүмүүсийг хангах		Тогтоолы н тоо	22	30	2025 онд тусгай шалгалтын сонгон шалгаруулалтыг 5 удаа, давхардсан тоогоор 203 сул ажлын байрны тусгай шалгалтыг зохион байгуулж, шалгалтад тэнцсэн 72 иргэнийг нэр дэвшүүлж 68 иргэнийг сул ажлын байранд томилсон шийдвэр нь томилох эрх бүхий байгууллагаас ирсэн. 2 ажлын байрыг авилгатай тэмцэх газраас албан бичиг нь ирэхээр томилохоор хүлээж байна. 2 иргэнийг томилох эрх бүхий албан тушаалтан бүтэц орон тооны цомхтголтой холбоотой томилоогүй болно.	100
11.	Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн санг журмын дагуу бүрдүүлж, судалгааг гарган, нөөцийн сангийн мэдээллийг сонирхогч байгууллагуудад хүргэж ажиллана.		Нөөц бүрдүүлэх судалгаан ы тоо	4	4	2025 оны ерөнхий шалгалтын бүртгэлд нийт 328 иргэн хамрагдаж, шалгалтад 262 иргэн орж, 2025 оны I-IV улирлын ерөнхий шалгалтад нийт 87 иргэн тэнцэж, нөөцөд бүртгэгдлээ	100
12.	Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн санг журмын дагуу бүрдүүлж, судалгаа гаргах.		Нөөцийн санг бүрдүүлсэ н судалгаа	1	1	2025 онд төрийн албаны ерөнхий шалгалтад орж тэнцсэн 87 иргэдийг журмын дагуу нөөцийн судалгаанд бүртгэсэн.	100

ГУРАВ: ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Зорилт 3.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлыг зохион байгуулах, төрийн албаны шинэтгэл, хүний нөөцийн удирдлагын системийг хэрэгжүүлэх, албан тушаалын тодорхойлолтыг хянуулах

12.	Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлэх албан хаагчдын судалгааг гаргаж, тангараг өргүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	Тангараг өргүүлэх тоо	3	2	Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 84 дүгээр зарлигаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам"-ын 2.1, 2.3 дахь заалтын дагуу тангараг өргөх үйл ажиллагааг зохион байгуулж, 2025 онд нийт 51 төрийн жинхэнэ албан хаагч тангараг өргөлөө. Тангараг өргөх үйл ажиллагаа 2025.07.03-ны Шүүхийн Тамгын газрын 2 албан хаагч байгууллага дээрээ, 2025.11.25-ны өдөр Аймгийн ЗДТГ-ын байранд 49 албан хаагч тангараг өргөлөө.	100
13.	Төрийн албан хаагчид зэрэг дэв шинээр болон ахиулан олгох саналыг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын захирамж гаргах	Санал ирүүлсэн албан хаагчдын тоо	187	200	Тайлант хугацаанд ахлах түшмэлийн зэрэг- 25, дэс түшмэлийн зэрэг- 159, туслах түшмэлийн зэрэг-3, нийт 187 төрийн албан хаагчийн зэрэг дэвийг Төрийн албаны тухай хууль, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын дагуу шинээр олгох, ахиулах шийдвэрийг аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Б/30 дугаар захирамжаар гаргалаа.	100
14.	Төрийн байгууллагуудын албан тушаалын тодорхойлолтыг хянан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	Хянуулсан байгууллагын тоо	4	3	2025 онд шинээр Аймгийн ЗДТГ-н мэргэжилтнүүд, Аймгийн ЗДТГ-ын 7 хэлтсийн дарга, Аймгийн ЗДТГ-ын ОНХС мэргэжилтэн, ХХААГ-ын дарга, сумдын ХААТ-н мэргэжилтэн, Аймгийн архивын хэлтсийн дарга, байцаагчийн 2 албан тушаалын тодорхойлолтуудыг хянаж, санал хүргүүлэн, төрийн албаны зөвлөлд хүргүүлснээр нийт 19 албан тушаалын тодорхойлолтод Төрийн албаны зөвлөл зөвшөөрөл олгож, томилох эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрээр баталгаажууллаа.	

15.	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухай бүр шийдвэрлэн хариуг хүргүүлэн ажиллах.	Шийдвэрлэлтийн хувь	100	100	2025 онд салбар зөвлөлд нийт 13 иргэний өргөдөл, хүсэлт ирснийг хугацаанд нь шийдвэрлэн хариуг холбогдох иргэнд хүргүүлсэн.	100
16.	Төрийн албаны зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулж, хариу хүргүүлэх.	Хэрэгжилтийн хувь	100	100	Төрийн албаны зөвлөлөөс 2025 онд салбар зөвлөлд 26 хугацаатай албан бичиг, судалгаа ирснийг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. Мөн цаг үеийн холбогдолтой мэдээ тайланг хугацаанд нь чанартай хүргүүлж ажилласан.	100
17.	Салбар зөвлөлийн 2025 онд гарсан тогтоол шийдвэр, ирсэн, явсан бичгийн бүртгэлийг хөтөлж, архивлах.	Хадгаламжийн нэгжийн тоо	10	10	2025 онд салбар зөвлөлийн хуралдааныг 10 удаа зохион байгуулж, 63 тогтоол гаргаж, 242 албан бичиг хүлээн авч, 149 албан бичгийг боловсруулан гаргаж, баталгаажуулан бүртгэл хөтлөн ажилласан.	100
18.	Төрийн албаны салбар зөвлөлийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлэлцэж батлуулах.	Хэрэгжилтийн хувь	100	100	Төрийн албаны салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 23 -ны өдрийн нэгдүгээр хуралдаанаар 3 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
19	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн жилийн ажлын тайланг хагас бүтэн жилээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх	Тайлангийн тоо	2	2	Салбар зөвлөлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас болон бүтэн жилээр тайлан мэдээг гаргаж, хугацаанд нь төрийн албаны зөвлөлийн ажлын албанд хүргүүлэн ажиллалаа	100

БИЕЛЭЛТИЙГ ҮНЭСЭН:

ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ш.ЭРДЭНЭБАТ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

М.ТУУЛ